



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 72

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Малын удмын сангийн үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй, засвар хийхэд эдийн засгийн хувьд үр ашиггүй 3 нэрийн нийт 17,383,935.00 /арван долоон сая гурван наян гурван мянга есөн зуун гучин тав/ төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Малын удмын сангийн үндэсний төвийн захирал П.Ганхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ



13201141

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 03 дугаар сарын 09 өдрийн
... дугаар тогтоолын хавсралт



**Малын удмын сангийн үндэсний төвийн үндсэн хөрөнгөд
бүртгэлтэй, акталж данснаас хасах хөрөнгийн жагсаалт**

№	Автомашины марк, улсын дугаар, арал	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1.Завхан аймгийн цөм сүрэг салбар нэгж						
1	УАЗ-469 4032- ЗАН 50524194	2005/2005	ш	1	2,750,000.00	2,750,000.00
Хэсгийн дүн				1		2,750,000.00
2.Увс аймгийн цөм сүрэг салбар нэгж						
2	УАЗ-469 9915- УБЭ 4050522	2005/2005	ш	1	4,133,935.00	4,133,935.00
Хэсгийн дүн				1		4,133,935.00
3.Баянхонгор аймгийн цөм сүрэг салбар нэгж						
3	Ланд круизер- 80 9910-УБР FZJ80006771 7	1994/2008	ш	1	10,500,000.00	10,500,000.00
Хэсгийн дүн				1		10,500,000.00
НИЙТ ДҮН						17,383,935.00 /арван долоон сая гурван наян гурван мянга есөн зуун гучин тав/